



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 20 өдөр

Дугаар 7/472

Арвайхээр сум

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үнэлгээний хорооны 2023 оны 07 дугаар сарын 20-ны өдрийн 86 дугаар дүгнэлтийн дагуу ӨВАОНӨГ/202306065/01/01 урилгын дугаартай Зүүнбаян-Улаан сумын Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн байрын дээврийн засварын ажлыг 57,301,058 (тавин долоон сая гурван зуун нэг мянга тавин найм) төгрөгөөр Дөлгөөн-Арвай ХХК-иар гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Тендерт шалгарсан аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээн авахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Т.Ариунболд)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ОРЛОГЧ



И.ДОРЖСҮРЭН

6223 11 0928

D:My Doc. Zahiramj. Zasag darga